



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 30 өдөр

Дугаар

111

Амардалай

Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16 дах заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дах заалт, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2, 38 дугаар зүйлийн 38.4 дэх заалтууд болон газар эзэмших эрхийг шилжүүлэн авах иргэний хүсэлтийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлгэрцогт сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэр Нүхэн-д байршилтай 5000 м.кв (0.5 га) өвөлжөө, хаваржааны зориулалттай газрын эзэмшигч иргэн Чагнаа овогтой Сугирдорж (ЗЕ41021516) нь 2021 оны 12 дугаар сарын 19-ны өдөр нас барсан. Иймд хүү Сугирдорж овогтой Гантөгс (ЗЕ82022712)-т уг газрыг зориулалтаар нь үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2015 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн А/15 тоот захирамжийн иргэн Ч.Сугирдорж-д холбогдох хэсэг мөн газар эзэмших 000566710 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

3. Газар эзэмшигч иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулан гэрчилгээ олгон газрын ашиглалтад хяналт тавьж ажиллахыг газрын даамал (Д.Цэнд-Аюуш)-д даалгасугай.

4. Эзэмшил газраа байгаль орчинд сөрөг нөлөөгүй зориулалтын дагуу эзэмшихийг газар эзэмшигчид үүрэг болгосугай.

ДАРГА

М.БАЯРСҮХ

488001257